



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 17 өдөр

Дугаар А/341

Есөнбулаг сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.7 дахь заалт, Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.1 дэх заалт, "Боловсролын чанарыг сайжруулах" хөтөлбөрийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2025 оны 15 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Спортын мастер Д.Мөнх-Эрдэнэд шаардлагатай байгаа хүүхэд залуучуудыг сурын сургалт хичээллүүлэх материаллаг баазыг бүрдүүлэх дэмжлэгт шаардагдах 5,000,000 (таван сая) төгрөгийг Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөр урамшуулал арга хэмжээний батлагдсан зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

2. Захирамжийн хэрэгжилтийг хангаж, хөрөнгийн зарцуулалтыг тайлагнан ажиллахыг нийгмийн бодлого (Ж.Амгаланбаатар)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хяналт, гүйцэтгэл, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ), Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

